

МӨНГӨНИЙ ТОЙМ

2010 оны 12 дугаар сар

Инфляци


Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2010 онд Улаанбаатар хотын инфляци 14.3 хувь, улсын хэмжээнд 13.0 хувиар өсөв. 2010 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын болон улсын инфляци 2.4 хувиар тус тус өсчээ.

Махны үнийн өсөлт Улаанбаатар хотын сарын инфляцид гол нөлөө үзүүлжээ. Сарын инфляцийг 100 хувь гэж авч үзвэл хүнсний бүлгийн үнийн өсөлт 94.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 3.0 хувийг бүрдүүлсэн байна.



ХҮИ-ийн сагсыг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний 12 бүлгийн бүх бүлгийн үнэ 2010 онд өсчээ. Эдгээрээс хүнсний барааны үнэ 20.6 хувиар, боловсролын үйлчилгээний үнэ 20.4 хувиар, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 16.9 хувиар тус тус нэмэгдсэн нь өндөр өсөлттэй бүлгүүд байлаа. Тухайн бүлгийн сагсанд эзлэх жинг харгалзан үнийн өөрчлөлтийг авч үзвэл сагсанд харьцангуй жин багатай холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний (4.1 хувийн жинтэй) үнэ нэлээд нэмэгдсэн ч индекс үзүүлэх нөлөө нь бага байсан бол сагсанд том жин эзэлдэг хүнс (41.1 хувийн жинтэй), хувцас бөс бараа, гутал (12.4 хувийн жинтэй) болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн (13.4 хувийн жинтэй) үнийн өсөлт тус индекс харьцангуй хүчтэй нөлөөлсөн байна.

Инфляцийн хүлээлт, эрэлтийн хүчин зүйлсийг илүү бодитой илэрхийлэх, нийлүүлэлтийн огцом цочролоос ялгаж шинжлэх үүднээс улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү, хүнсний ногоо эсвэл түр зуурын нөлөөлөлд автан хэт их хэлбэлздэг бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч “суурь инфляци”-ийг тооцдог. Суурь инфляци 2010 онд 9.4 хувиар өссөн байна. Үүнд хэрэглээний сагсны бүх бүлгүүдийн үнийн тогтвортой өсөлт жигд байдлаар нөлөөлсөн бөгөөд тэр дундаас хүнсний бүлэг, боловсролын үйлчилгээ, хувцас, бөс бараа, гутлын бүлэг болон орон сууц, ус цахилгаан, түлшний үнийн өсөлт нь харьцангуй хүчтэй нөлөө үзүүлэв.




Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт¹ 2010 онд 62.5 хувиар өсч 4680.0 тэрбум төгрөгт хүрчээ. 2009 оны 10 дугаар сараас хойш хурдацтай өсч буй мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2010 оны дунд үеэс эхлэн тогтворжих хандлагатай буюу 44.5-45.2 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол 2010 оны 12 дугаар сард уул уурхайн салбарын их хэмжээний хөрөнгө гаднаас орж ирсэн, засгийн газрын зардал, санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэв.


2009 оны сүүлээр M2 мөнгөний өсөлтийн 50 гаруй хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байсан бол аажмаар төгрөгийн хагдаламжийн нөлөө нэмэгдэж оны эцсийн байдлаар нийт мөнгөний өсөлтийн 42.6 хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн байна. Үүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн чангаралт нөлөөлжээ. Харин гадаад валютын харилцахын нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд үзүүлж буй нөлөө харьцангуй тогтвортой байгаа бөгөөд тайлант сард M2 мөнгөний өсөлтийн 21.9 хувийг бүрдүүлсэн байна. Төгрөгийн харилцахын өсөлт 2010 онд 14.6 нэгж хувиар нэмэгдэж, оны эцсийн байдлаар нийт мөнгөний өсөлтийн 22.4 хувийг бүрдүүлэв.

¹ M2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.



Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн


Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг эх үүсвэр талаас нь авч үзвэл, төгрөгийн хадгаламж 42.8 хувь, гадаад валютын хадгаламж 16.1 хувь, гадаад валютын харилцах 16.4 хувь, банкнаас гадуурх мөнгө 8.3 хувь, төгрөгийн харилцах 16.4 хувийг тус тус бүрдүүлсэн байна.



Хадгаламж

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 48.5 хувиар өсч 2756.2 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хадгаламжийн жилийн өөрчлөлт 2009 оны эцсээс харьцангуй тогтворжиж 35 орчим хувьтай байсан бол 2010 оны 12 сард 10.5 нэгж хувиар өсчээ. Харин бүтцээр нь авч үзвэл төгрөгийн хадгаламж илүү хурдтай өсч, валютын хадгаламжийн өсөлт саарч байгаа хандлага ажиглагдаж байна. Төгрөгийн ханш чангарахад иргэд хуримтлалаа гадаад валютаар хадгалуулах сонирхол нь буурч төгрөгийн хадгаламж руу шилжүүлдэг, нөгөө

талаас үзүүлэлтүүд төгрөгөөр илэрхийлэгддэг тул ханшийн өөрчлөлтөөс валютын хадгаламжийн үлдэгдэл нь буурч харагддаг.



Нийт хадгаламжийн 72.6 хувь нь төгрөгийн, 27.4 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.1 нэгж хувиар өсчээ.

Нөөц мөнгө


Нөөц мөнгө 2010 онд 29.0 хувиар өсч 945.5 тэрбум төгрөгт хүрэв. Нөөц мөнгөний өсөлтөд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж өссөн нь гол нөлөө үзүүлжээ. Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оноос 4.1 нэгж хувиар буурсан бол банкуудын касс 1.9 нэгж хувь, банкнаас гадуурх мөнгө 2.2 нэгж хувиар өссөн байна.

Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив 2010 онд 78.7 хувиар өсч 2739.3 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив 44.1 хувиар өсч 1940.7 тэрбум төгрөгт хүрэв. Гадаад цэвэр активын жилийн өсөлт 2010 оны эхнээс тасралтгүй буурч байсан бол 12 дугаар сард мэдэгдэхүйц буюу 39.1 нэгж хувиар өсөв. Үүнд гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2010 оны 12 дугаар сард 23.7 хувь буюу 400.7 сая ам.доллараар нэмэгдсэнээс шалтгаалжээ. Банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийг дотоод зээлд байршуулах нь нэмэгджээ. Үүний улмаас 2010 оны дунд үеэс эхлэн зээл олголтын хэмжээ нэмэгдсэнээр дотоод цэвэр актив их хэмжээгээр өслөө. Тухайлбал, дотоод цэвэр активын жилийн өсөлт нь 2010 оны 5 дугаар сараас 40.9 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 58.5 хувь нь гадаад цэвэр активт, 41.5 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна. Гадаад цэвэр

активын М2 мөнгөнд эзлэх хувь 2010 онд 5.3 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.



Зээл


Хадгаламжийн байгууллагуудаас² олгосон зээл 2010 онд 23.0 хувиар өсч 3264.8 тэрбум төгрөгт хүрчээ. Зээл олголтын хэмжээ 2010 оны дунд үеэс нэмэгдэж хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл буурч байна. Хувийн хэвшилд олгож буй зээлийн жилийн өсөлт 2009 оны турш буурч байсан бол 2010 оны эхнээс харьцангуй тогтворжих хандлагатай байна. Харин иргэдийн зээлийн хэмжээ сүүлийн саруудад хурдацтай нэмэгдэж нийт зээлийн өсөлтийн гол хүчин зүйл болж байна. Хувийн хэвшилд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт өнгөрсөн оноос 0.8 нэгж хувиар буурсан бол иргэдийнх 62.0 нэгж хувиар өсчээ. Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 57.2 хувь нь хувийн хэвшил, 41.9 хувь нь иргэд, 0.5 хувь нь улсын байгууллага, 0.3 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 85.8 хувийг хэвийн зээл, 2.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 11.5 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин 2009 оны 12 дугаар сард 2000 оноос хойш хамгийн өндөр цэгтээ буюу 17.4 хувьд хүрсэн боловч 2010 оны турш аажмаар буурсан байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын³ нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2010 оны эцсийн байдлаар 62.3 тэрбум төгрөг байв. Нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан санхүүжилт нь 3327.0 тэрбум төгрөг байлаа.

² Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

³ Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага орно.



Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2010 онд 0.2 нэгж хувиар өсч жилийн 10.99 хувьтай болов. Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү⁴ үргэлжлэн буурсаар байна. Тухайлбал, төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оноос 2.9 нэгж хувиар буурч 17.9 хувь болсон бол гадаад валютынх 3.9 нэгж хувиар буурч 12.6 хувь болжээ. Мөн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү буурах хандлагатай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2010 онд 2.2 нэгж хувиар буурч 10.7 хувь болсон бол валютынх 2.3 нэгж хувиар буурч 4.0 хувь болов. Харин төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү бага зэрэг өсч жилийн 3.2 хувьд хүрчээ.

Мөнгөний зах

2010 оны 12 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 555.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 1.0 хувь нь овернайт зээл, 1.3 хувь нь банк хооронд олгосон зээл, 24.8 хувь нь банк хоорондын хадгаламж, 35.6 хувь нь ТБҮЦ-ны хоёрдогч арилжаа, 37.3 хувь нь репо нөхцлөөр олгосон зээл байв. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 9.45 хувь байлаа.

2010 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2010 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 133.9 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 74.2 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 160.7 тэрбум төгрөг, валютын нөөцөд 134.3 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

⁴ Зарласан хүү.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2010 оны эцэст 1256.47 төгрөг болж, өмнөх оноос 200 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2010 онд дунджаар 1355.93 төгрөг байв.

МОНГОЛБАНК